



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Нийгмийн халамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.3, 18 дугаар зүйлийн 18.2.8-т заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Нийгмийн халамжид хамрагдагсдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг нэгдүгээр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын тайлангийн маягтыг хоёрдугаар, нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тайлангийн маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулах, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат)-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хоёр жил тутамд хяналт үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

САЙД  Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
08 сарын 06 өдрийн 174 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт




**Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн
тусламж, үйлчилгээ үзүүлэх журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.3, 18 дугаар зүйлийг 2.8 заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, тусламж үйлчилгээний зардлыг бүртгэх, нөхөн төлбөр хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. Энэхүү журамд дараах нөхцөлийг хангасан өрхийн гишүүн-иргэн болон гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэн /цаашид нийгмийн халамжид хамрагдагсад гэх/ хамрагдана.
 - 1.2.1. Үндэсний статистикийн хороо болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан аргачлалын дагуу амьжиргааны түвшингээ үнэлүүлж, өрхийн гишүүн-иргэний мэдээллийн нэгдсэн санд орсон;
 - 1.2.2. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнээс тухайн онд хүнсний эрхийн бичиг олгохоор Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан босго онооноос доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүн;
 - 1.2.3. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн хэлтсээс явуулсан судалгаагаар гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэн гэж тодорхойлогдсон иргэд.

**Хоёр. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл
ажиллагааны удирдлага, зохион байгуулалт**

- 2.1. Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношлогоо эмчилгээний төв, өрх сумын эрүүл мэндийн төв болон эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар болон орон нутгийн нийгмийн даатгалын хэлтэс оролцоно.
- 2.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг зохион байгуулна.
- 2.3 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 2.3.1 Журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн



газрыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах журмын хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газартай хамтран зохион байгуулна.

- 2.3.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар дундын мэдээллийн хороотой гэрээ байгуулан ажиллана.
- 2.3.3. Нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлсэн эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг холбогдох стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу чанартай, зохистой хийгдсэн эсэх, тусламж, үйлчилгээний зардлыг Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль, тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хяналт тавих, тайлагнах талаар Нийгмийн Даатгалын Ерөнхий Газартай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангана.
- 2.3.4. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь 1.2.2-т заасан иргэдийн овог нэр, хүйс, регистрийн дугаар, насны ангилал, гэрийн хаяг, 1.2.3-т заасан иргэдийн овог нэр, хүйс, регистрийн дугаар, насны ангиллыг багтаасан мэдээллийн санг Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас жил бүрийн 6, 12 дугаар сарын 30-ны дотор албан болон цахим хэлбэрээр авч байршуулна.
- 2.3.5. Журмын 1.2.2-т заасан иргэдийн мэдээллийн санг ашиглахдаа Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан "Салбар дундын мэдээллийн санг удирдах, ашиглах журам"-ыг баримтална.
- 2.3.6. Журмын 1.2.2-т заасан иргэдийн мэдээлэл бүхий нэрсийн жагсаалтыг аймаг, сум, баг, дүүрэг, хороогоор ялгаж, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтэс, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт албан болон цахим хэлбэрээр тус тус хүргүүлнэ.
- 2.3.7. Журмын 1.2.3-т заасан орон нутагт суурьших иргэдийн мэдээлэл бүхий нэрсийн жагсаалтыг аймгаар ялгаж аймгийн Эрүүл мэндийн газар болон орон нутгийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлнэ.
- 2.3.8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах Улаанбаатар хотод суурьших гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн мэдээллийг Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Энэрэл эмнэлэгт албан болон цахим хэлбэрээр тус тус хүргүүлнэ.
- 2.3.9. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь нийгмийн халамжид хамрагдагсдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмийн сантай хийх гэрээний загварыг боловсруулан батлуулна.
- 2.3.10. Нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний тоог жил бүр нэгтгэн, "Эрүүл мэндийн үзүүлэлт" эмхэтгэлд оруулна.

Гурав. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц



3.1. Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан, хоёрдогч шатлалын эмнэлгүүд эрүүл мэндийн даатгалаас санхүүжих 4 төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Амбулаторийн тусламж, үйлчилгээ
- Оношлогоо шинжилгээ
- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

3.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан эмийг жорын дагуу үнэ төлбөргүй олгоно.

3.3. Амбулаторийн тусламж, үйлчилгээнд орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношлогоо эмчилгээний төвд үзүүлдэг эмчийн үзлэг, зөвлөгөө, шархны анхдагч цэвэрлэгээ, боолт, эмчилгээ сувилгааны ажилбарууд болон ажилбарт шаардлагатай эмчилгээний нэг удаагийн хэрэгслүүд хамаарна.

3.4. Оношлогоо шинжилгээнд орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношлогоо эмчилгээний төвд үзүүлдэг дараах шинжилгээг хамруулна. Үүнд:


- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- Шээсний шинжилгээ
- Биохимийн шинжилгээ
- Иммунологийн шинжилгээ
- Бактерлогийн шинжилгээ
- Рентген оношлогоо
- Хэт авиан оношлогоо
- Маммографи
- Умайн хүзүүний эсийн шинжилгээ
- Цитологи, гистологийн шинжилгээ
- Серологийн шинжилгээ
- Зүрхний цахилгаан бичлэг
- Тархины цахилгаан бичлэг
- Дурангийн шинжилгээ

3.5 Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд аймаг, дүүрэг, орон нутгийн, нэгдсэн эмнэлгүүд, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, БОЭТ-д үзүүлдэг дараах төрлийн тусламж, үйлчилгээг хамруулна. Үүнд:

- Дотор
- Мэдрэл
- Хүүхдийн тусламж, үйлчилгээ
- Мэс засал, гэмтэл /хоёрдогч шатлалын/
- Уламжлалт эмчилгээ
- Эмэгтэйчүүд /Жирэмслэлт, төрөлттэй холбоогүй/

3.6. Нийгмийн халамжид хамрагдагсад төрөөс хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, журмын дагуу үзүүлнэ.

Дөрөв. Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, тэдгээрийн үүрэг



4.1. Нийгмийн халамжид хамрагдагсад өрх, сумын эрүүл мэндийн төв, орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношлогоо эмчилгээний төв болон эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан нь журмын гуравдугаар бүлэгт тусгасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.2. Улаанбаатар хотод суурьших гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдэд Энэрэл эмнэлэг болон эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан нь журмын гуравдугаар бүлэгт тусгасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.3. Орон нутагт суурьших гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэнд өрх, сумын эрүүл мэндийн төв, орон нутаг, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв болон эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан нь журмын гуравдугаар бүлэгт тусгасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.4. Эрүүл мэндийн байгууллага, даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан нь нийгмийн халамжид хамрагдагсад тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох бичиг баримтыг иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээтэй тулган нягтална.

4.5. Эрүүл мэндийн байгууллага, даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан нь нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө.


4.6. Орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Энэрэл эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв, даатгалын байгууллагатай гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан нь нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын нэхэмжлэл, холбогдох маягуудыг хяналт, үнэлгээ, аудитийн шалгалтад бэлэн хадгална.

4.7. Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтанууд нь нийгмийн халамжид хамрагдагсадтай хуйвалдах,эрх мэдлээ буруугаар ашиглах зэрэг тохиолдолд тэдгээрт холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.8. Өрх, сумын эрүүл мэндийн төв нь дараах үүрэгтэй. Үүнд:

4.8.1. Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө.

- 4.8.2. Өрх, сум, багийн эмч нь нийгмийн халамжид хамрагдагсдад эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн эсэхээс үл хамааран зохих эмнэл зүйн удирдамж, стандартын дагуу тусламж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд журмын гуравдугаар бүлэгт заасан тусламж, үйлчилгээг авахаар орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношлогоо эмчилгээний төвийн нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, оношлогоо шинжилгээ хийлгэх, хэвтүүлэн эмчлүүлэхээр илгээнэ.
- 4.8.3. Өрх, сум, багийн эмч нь эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлттэй олгодог зайлшгүй шаардлагатай эмийг "эмийн жорын маягт, жор бичилт" MNS 5376:2011 стандартын дагуу ерөнхий нэршлээр бичих бөгөөд жорын хуудасны дээд хэсэгт холбогдох бичиг баримтын дугааруудыг бичнэ.
- 4.9. Орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Энэрэл эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв нь дараах үүрэгтэй. Үүнд:
- 4.9.1. Нийгмийн халамжид хамрагдагсдын регистрийн дугаар, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээний дугаар зэрэг холбогдох мэдээллүүдийг тухайн эрүүл мэндийн байгууллагын бүртгэлд оруулж, иргэнд тусламж, үйлчилгээ авах дугаар өгнө.
- 4.9.2. Нийгмийн халамжид хамрагдагсдад эрүүл мэндийн даатгалаас санхүүжих амбулатори, оношлогоо шинжилгээ, хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ "Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг бүртгэх, мэдээлэх журам"-ын тухай Эрүүл мэндийн сайдын хүчин төгөлдөр мөрдөж буй тушаалын дагуу бүртгэнэ.
- 4.9.3. Нийгмийн халамжид хамрагдагсдад амбулатори, оношлогоо шинжилгээ, хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ хүчин төгөлдөр мөрдөж буй "Эмчийн үзлэгийн бүртгэл", оношлогоо шинжилгээний маягт, өвчний түүхэнд холбогдох бичиг баримтын дугаарыг бичнэ. Нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлыг хянаж тооцохдоо хүчин төгөлдөр эрх зүйн актыг дагаж мөрдөнө.
- 4.9.4. Орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Энэрэл эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлыг нягтлан хянаж, нэхэмжлэлийг бэлтгэн нийгмийн даатгалын байгууллагад энэ журамд заасан хугацаанд хүргүүлнэ.
- 4.9.5. Нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний тайланг тушаалын хоёрдугаар хавсралтын А-д заасан маягтын дагуу сар бүр нэгтгэн улиралд нэг удаа дараа сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.
- 4.10. Нийгмийн даатгалын байгууллагатай даатгалын гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан нь дараах үүрэгтэй. Үүнд:
- 4.10.1. Нийгмийн халамжид хамрагдагсдад эмийн ерөнхий нэршлээр бичсэн жорын дагуу чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилж эм олгоно.




- 4.10.2. Сонгогдсон эмийн сан нийгмийн халамжид хамрагдагсад зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэхдээ Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох эмийн тухай” хүчин төгөлдөр мөрдөж буй журмыг баримтална.
- 4.10.3. Сонгогдсон эмийн сан нийгмийн нийгмийн халамжид хамрагдагсад тусламж үйлчилгээ үзүүлэхдээ нийгмийн даатгалын ерөнхий газрын программ хангамжид холбогдох мэдээллийг бүртгэнэ. Интернетэд холбогдоогүй эмийн сан хүчин төгөлдөр мөрдөж буй маягтад мэдээллийг бүртгэнэ.
- 4.10.4. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлыг хянаж тооцохдоо хүчин төгөлдөр эрх зүйн актыг дагаж мөрдөнө.
- 4.10.5. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлыг нягтлан хянаж, нэхэмжлэлийг бэлтгэн нийгмийн даатгалын байгууллагад дараа сарын 5-ны дотор хүргүүлнэ.
- 4.10.6. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн тусламж, үйлчилгээний тайлан хоёрдугаар хавсралтын Б-д заасан маягтын дагуу сар бүр нэгтгэн, улиралд нэг удаа дараа сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.


Тав. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлыг олгох үйл явц

5.1. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нь дараах хувь хэмжээтэй байна. Үүнд:

№	Тусламж үйлчилгээ	Зардлын хувь хэмжээ	
		Даатгалтай иргэн	Даатгалгүй иргэн
1	Үнийн хөнгөлөлттэй эм	Эмийн төрлөөс хамаарч ЭМД-ын сангаас хөнгөлөлт олгох жагсаалтад заасан хувь хэмжээний дагуу ЭМД сангаас тодорхой хувь нь, үлдсэн нь төсвөөс	100% төсвөөс
2	Амбулатори	100% ЭМД-ын сангаас	100% төсвөөс
3	Оношлогоо шинжилгээ	Хүчин төгөлдөр эрх зүйн актын хүрээнд зохицуулсан ЭМД-аас төлөх оношилгоо шинжилгээний төлбөрийн хэмжээгээр ЭМД-ын сангаас	Хүчин төгөлдөр эрх зүйн актын хүрээнд зохицуулсан ЭМД-аас төлөх оношилгоо шинжилгээний төлбөрийн хэмжээгээр төсвөөс
4	Хэвтүүлэн эмчлэх	90% ЭМД-ын сангаас, хамтын төлбөр 10% төсвөөс	100% төсвөөс



- 5.2. Нийгмийн халамжид хамрагдагсад олгох эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын жилийн дээд хязгаар нь ИЭМД-ын хуульд заасан дээд хязгаартай адил байна.
- 5.3. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн үнийн хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний зардлыг нэхэмжлэх үйл явц
- 5.3.1. Нийгмийн даатгалын байгууллагатай даатгалын гэрээ бүхий сонгогдсон эмийн сан, эмийн эргэлтийн сан нь үнийн хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээ авсан нийгмийн халамжид хамрагдагсад тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас, төсвөөс гэж ялган нэхэмжлэлийг 2 хувь бэлтгэн жагсаалт, жорын хамт Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтэст бичгээр болон цахим хэлбэрээр дараа сарын 5-ны дотор илгээнэ.
- 5.3.2. Нийгмийн даатгалын байгууллага нэхэмжлэлийг ажлын 10 өдөрт багтаан хянаж төсвөөс олгох зардлын тайланг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт гуравдугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэн хүргүүлнэ.
- 5.3.3. Нийгмийн даатгалын байгууллага нь ЭМД-ын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох эмийн зардлыг ажлын 10 өдөрт багтаан, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь төсвөөс олгох эмийн нөхөн олговрыг Нийгмийн даатгалын байгууллагаас тайлан хүлээн авсанаас хойш ажлын 5 өдөрт багтаан эмийн санд шилжүүлнэ.
- 5.3.4. Нийгмийн даатгалын байгууллага нь тусламж, үйлчилгээ авсан иргэдийн жагсаалт болон нэхэмжлэлийг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь тайлан болон нэхэмжлэлийг, эмийн сан нь жагсаалт, нэхэмжлэл болон жорыг сар тус бүрээр хадгална.
- 5.4. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн амбулатори, оношлогоо шинжилгээ болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний зардлыг нэхэмжлэх үйл явц
- 5.4.1. Орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Энэрэл эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтан амбулатори, оношлогоо шинжилгээ болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авсан нийгмийн халамжид хамрагдагсдын жагсаалтыг нэхэмжлэл, өвчний түүх, холбогдох бичиг, баримтын хамт эрүүл мэндийн даатгалын сангаас, төсвөөс олгогдох зардал гэж ялган 2 хувь бэлтгэн бичгээр болон цахим хэлбэрээр сар бүрийн 5 ба 20-ны өдрийн дотор нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлнэ.
- 5.4.2. Нийгмийн даатгалын байгууллага нэхэмжлэлийг ажлын 10 өдөрт багтаан хянаж төсвөөс олгох зардлын тайланг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт гуравдугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэн хүргүүлнэ.




- 5.4.3. Нийгмийн даатгалын байгууллага нь ЭМД-ын сангийн төлбөрийг ажлын 10 өдөрт багтаан, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь төсвөөс олгох зардлыг Нийгмийн даатгалын байгууллагаас тайлан хүлээн авсанаас хойш ажлын 5 өдөрт багтаан аймаг, дүүрэг, орон нутгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Энэрэл эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төвд шилжүүлнэ.
- 5.4.4. Орон нутаг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Энэрэл эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн амбулатори, оношилгоо шинжилгээ, болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, нэхэмжлэлийг өвчний түүх, холбогдох бичиг баримтын хамт, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар төсвөөс олгох зардлын тайлан, нэхэмжлэлийг сар тус бүрээр хадгална.

Зургаа. Журмыг хэрэгжүүлэхэд оролцох бусад хамтрагч талууд, тэдгээрийн үүрэг


6.1. Журмын хэрэгжилтийг хангахад аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- 6.1.1. Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуудлаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллана.
- 6.1.2. Нийгмийн халамжид хамрагдагсад сургалт, мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 6.1.3. Нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эмийн сангуудаас байршил /орлого багатай иргэд төвлөрдөг гэр хороолол, захын хороолол, баг/, тухайн эмийн санг үйлчлэх хүрээний хүн амын тоотой уялдуулан сонгоно.
- 6.1.4. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн тусламж, үйлчилгээний тоонд үндэслэн дараа жилийн үйл ажиллагааны зардлыг төсөвлөн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 6.1.5. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн тусламж, үйлчилгээний тайланг хоёрдугаар хавсралтын В-д заасан маягтын дагуу сар бүр нэгтгэн улиралд нэг удаа дараа сарын 20-ны дотор ЭМХТ-д хүргүүлнэ.
- 6.1.6. Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлэг, эмийн сангуудын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ хийнэ.
- 6.1.7. Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад ямар нэг бэрхшээл гарсан тохиолдолд шийдвэрлэх арга хэмжээ авч, холбогдох байгууллагуудад мэдээлж хамтран ажиллана.
- 6.1.8. Нийгмийн халамжид хамрагдагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шаардлагатай тохиолдолд гарсан шийдвэр, дүгнэлтийг нийгмийн даатгалын байгууллага болон холбогдох байгууллагад мэдээлнэ.



6.2. Журмын хэргэжилтийг хангахад Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар нь дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- 6.2.1. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн эмийн үнийн хөнгөлөлт, амбулатори, оношлогоо шинжилгээ, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын нэхэмжлэлийг эдгээр иргэдийн эрүүл мэндийн даатгалтай, даатгалгүйгээс үл хамааран нягтлан хянана.
- 6.2.2. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу чанартай, зохистой хийгдсэн эсэх, тусламж, үйлчилгээний зардлыг хүчин төгөлдөр хэрэгжиж буй холбогдох тогтоол, тушаалын дагуу тооцсон эсэхэд хяналт тавина.
- 6.2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нь ИЭМД-ын тухай хуулиар тогтоосон даатгалын сангаас төлөх зардлын жилийн дээд хязгаарт хүрсэн нийгмийн халамжид хамрагдагсад мэдээллийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт гаргаж өгнө.
- 6.2.4. Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын нэхэмжлэл болон зардлын нэгдсэн тайланг хяналт үнэлгээ, аудитийн шалгалтад бэлэн хадгална.
- 6.2.5. Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар нь орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.



08...сарын...өдрийн...дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тайлангийн маягт

А. Эрүүл мэндийн байгууллага
 Аймаг/дүүрэг
 Эрүүл мэндийн байгууллагын нэр
 Тайлангийн сар
 Тайлан гаргасан огноо он сар өдөр

№	Хамрагдсан тусламж, үйлчилгээ	Үзүүлэлт	Хүний тоо	
			Эр	Эм
1	Амбулатори	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		
2	Оношлогоо, шинжилгээ	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		
3	Хэвтүүлэн эмчлэх	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		


Тайлан гаргасан:..... /Эрүүл мэндийн даатгал хариуцсан эмч/
 Тайланг хянасан:/Эрүүл мэндийн байгууллагын дарга/

Б. Эмийн сан
 Аймаг/ дүүрэг Сум/ хороо
 Эмийн сангийн нэр
 Тайлангийн сар
 Тайлан гаргасан огноо он сар өдөр

№	Хамрагдсан тусламж, үйлчилгээ	Үзүүлэлт	Хүний тоо	
			эр	эм
1	ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмээр үйлчлэх	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		

Тайлан гаргасан: /Санхүүгийн ажилтан/
 Тайланг хянасан..... / Эмийн сангийн эрхлэгч/

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
08 сарын 06 өдрийн 11 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт




В. Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тайлангийн маягт

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар
Тайлангийн улирал : он – улирал (..... - сар)
Тайлан гаргасан огноо он сар өдөр

№	Хамрагдсан тусламж, үйлчилгээ	Үзүүлэлт	Хүний тоо	
			Эр	Эм
1	Амбулаторийн	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		
2	Оношлогоо, шинжилгээ	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		
3	Хэвтүүлэн эмчлэх	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		
4	ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмээр үйлчлэх	Эрүүл Мэндийн даатгалтай		
		Эрүүл Мэндийн даатгалгүй		
		Нийт (хүйсээр)		
		Бүгд		

Тайлан гаргасан: /
Тайланг хянасан: /

/ Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын
статистикийн эмч/
/ Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын
дарга/орлогч



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
8 сарын 6 өдрийн 4 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
зардлын тайлангийн маягт**

НДЕГ-ын дэргэдэх ЭМДГ/орон нутгийн нийгмийн даатгалын хэлтэс/-ийн дарга

/Гарын үсэг/

.....аймаг /дүүрэг

Огноо.....

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Банкны нэр	Дансны дугаар	Зардлын зүйл	Үйлчлүүлсэн нийгмийн халамжид хамрагдагсдын тоо	Нийт зардал (төгрөгөөр)
1	Нэгдсэн эмнэлэг			Хамтын төлбөр		
2	Эмийн сан			Эмийн нөхөн төлбөр		
3	Эмийн сан			Эмийн нөхөн төлбөр		
	Нийт зардал					

ЭМД-ын хяналтын байцаагч,эмч Гарын үсэг

Хянасан нягтлан бодогч Гарын үсэг